



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.04.28 № 3Г-1/67
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000234002186



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 04. 28 № 101/973
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 57 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235008872



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn


2023.04.28 № **01/2715**

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000821



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023 04 27 № 1/2285
танай 2023 04 26 ны № 01/2652 -Т

**САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



151602153


А5 Файл.2023

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх", 8.1.2-т "Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж, мөн зүйлийн 8.1.3-т "Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах", Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах" гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2024 оны төсвийн зарлагын хязгаар, 2025-2026 оны дунд хугацааны зарлагын хязгаарын төсөөлөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл,

холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй байна.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024
ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**



УЛААНБААТАР ХОТ

2023 он

АГУУЛГА

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	4
1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв.....	4
1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага	5
1.3. Монгол Улсын эдийн засгийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл.....	7
1.4. Эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	15
1.5. Макро эдийн засгийн 2024 оны хандлага, 2025-2026 оны төсөөлөл, бодлогын чиглэл.....	16
1.6. Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл	18
2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ.....	20
3. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ	21
4. ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ	23
4.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл	23
4.1.1. Төсвийн орлого	23
4.1.2. Төсвийн зарлага.....	23
4.2. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл ...	23
4.2.1. Төсвийн орлого	23
4.2.2. Төсвийн зарлага.....	24
4.3. Нэгдсэн төсвийн үзүүлэлт.....	24
5. Монгол Улсын 2024-2026 оны нэгдсэн төсвийн төсөөлөл.....	25
5.1. Монгол Улсын 2024-2026 оны нэгдсэн төсвийн бодлого.....	25
5.2. Монгол Улсын 2024-2026 оны төсвийн орлогын төсөөлөл.....	26
5.3. Монгол Улсын 2024-2026 оны төсвийн урсгал зардлын чиглэлээр баримтлах бодлого	26
5.4. Төсвийн хөрөнгө оруулалт, бодлого зарчим, хүрэх үр дүн.....	28
5.4.1. Төсвийн хөрөнгө оруулалт 2018-2023 он	28
5.4.2. Төсвийн хөрөнгө оруулалт 2024-2026 он	28
5.4.3. 2024 онд баримтлах бодлого, шалгуур үзүүлэлт.....	29
5.5. Гадаад зээл, тусламжийн ашиглалт, баримтлах зарчмууд.....	30
6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ	31
6.1. Засгийн газрын өр	31
6.1.1. Улсын нийт гадаад өр.....	31
6.1.2. Засгийн газрын өр.....	32

6.1.3.	Засгийн газрын өрийн тухай тусгай шаардлага	32
6.1.4.	Засгийн газрын гадаад зээл	33
6.1.5.	Засгийн газрын гадаад үнэт цаас	34
6.1.6.	Засгийн газрын дотоод өр	35
6.2.	Засгийн газрын өрийн баталгаа	37
6.2.1.	МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа	37
6.2.2.	“Эрдэнэс Монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна	38
6.3.	Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг 38	
6.4.	Монгол Улсын Зээлжих зэрэглэл	43

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Сүүлийн саруудад дэлхий дахинд эрчим хүчний болон хүнсний үнийн өсөлт саарч, БНХАУ хөл хориогоо цуцалсан нь дэлхийн эдийн засгийн төлөвт эергээр нөлөөлж байна. Гэсэн хэдий ч Украинд болж буй дайн, төв банкнуудын мөнгөний хатуу бодлого зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан геополитикийн болон санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Олон улсын валютын сан (ОУВС)-гийн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2023 онд 2.8 хувиар, 2024 онд 3.0 хувиар өсөж, ирэх 5 жилийн өсөлт 3 орчим хувь буюу сүүлийн 20 жилийн дундаж болох 3.8 хувиас бага байх төлөвтэй байна.

График 2. Дэлхийн эдийн засгийн өсөлт /хувь/




График 1. Дэлхийн улсуудын инфляцын төлөв /хувь/



Эх сурвалж: Олон Улсын Валютын сан, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

БНХАУ: БНХАУ цар тахлын хөл хориог цуцалж, эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, түүхий эдийн эрэлтийг дэмжиж байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөвт эерэг хүлээлтийг бий болгож байна. БНХАУ-ын Засгийн газраас 2023 оны эдийн засгийн өсөлтийг 5 хувь орчимд хүргэх зорилтыг зарлаад байна. ОУВС тус улсын эдийн засгийн өсөлтийг 2023 онд 5.2 хувь, 2024 онд 4.5 хувь байна гэж тооцоолж байна.

График 3. Нийт эрэлтэд БНХАУ-ын эзлэх хувь (2020-2021 оны тоон мэдээлэл)



Эх сурвалж: "Эдийн засгийн төлөв" тайлан, OECD, 2023 оны 3 дугаар сар

ОХУ: Украинд болж буй дайн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний болон хүнсний хангамжид эрсдэл үүсгэн, улмаар үнийн өсөлтөд нөлөөлж байна. ОХУ-ын хувьд тус улсын эсрэг хориг арга хэмжээ авч буй улс орнуудтай хийх худалдаа буурсан ч бусад улсуудтай худалдааны эргэлтээ нэмэгдүүлсэн нь ОХУ-ын экспортод

- үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж байна. ОУВС тус улсын эдийн засгийн өсөлтийг 2023 онд 0.3 хувь, 2024 онд 2.1 хувь байна гэж тооцоолж байна.
- **АНУ:** АНУ-ын инфляц зорилтот түвшнээс өндөр хэвээр байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн халалт намжиж, Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогыг чангаруулах эрчмийг бууруулж, бодлогын хүүгийн өсөлтийг 0.75 нэгж хувиас 0.25 нэгж хувь болгон бууруулаад байна. Мөнгөний хатуу бодлого хэрэглээ, хөрөнгө оруулалтаар дамжин эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж, АНУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд 1.4 хувь, 2024 онд 1 хувь байна гэж ОУВС тооцоолж байна.
- **Евро бүс:** Европын төв банк инфляцын өсөлтийг хязгаарлах зорилгоор хасах хүүгийн бодлогоо зогсоож, бодлогын хүүг 3 хувь хүртэл нэмэгдүүлээд байна. Украинд болж буй дайнаас шалтгаалсан ОХУ-ын байгалийн хийн нийлүүлэлтийн бууралтаас үүдэлтэй Европын эрчим хүчний хямралын эрсдэл хэвээр байна. Эрчим хүчний үнийн өсөлт, мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд 0.7 хувьд хүрэх ч 2024 онд 1.6 хувь болж нэмэгдэхээр хүлээгдэж байна.

1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

- **Зэсийн үнэ.** 2023 оны эхний 3 сард дунджаар 8,959 ам доллар болж, өмнөх оны дунджаас 1.9 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлт удаашрах болон БНХАУ-ын үл хөдлөх, барилгын салбарын хямрал үргэлжилж болзошгүй зэрэг эрсдэлээс шалтгаалан зэсийн эрэлт 2023 онд сул хэвээр байх төлөвтэй байна.



График 4. Зэсийн үнэ /ам.доллар/тонн/



График 5. Алтны үнэ /ам.доллар/трой унц/

- **Алтны үнэ.** 2023 оны эхний 3 сард дунджаар 1,891 ам доллар/унци болж, өмнөх оны дунджаас 4.9 хувиар өслөө. Украинд дайн эхэлсний дараа алтны үнэ 1 унц нь 2,000 орчим ам.доллар буюу бүх цаг үеийн дээд цэгтээ хүрсэн ч 2022 оны 8 дүгээр сараас эхлэн аажмаар буурч 11-н сард 1,700 орчим ам.доллар болов. Төв банкууд бодлогын хүүгээ өсгөж эхэлснээр алтанд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бууруулсны зэрэгцээ ам.долларын ханш ихэнх валютын эсрэг чангарч байгаа нь алт худалдан авах зардлыг

● нэмэгдүүлсэн. Дэлхийн банкны үзэж байгаагаар 2023 онд ам.долларын ханш суларч, зээлийн хүү буурах магадлалтай байгаа нь алтны үнэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

● **Төмрийн хүдрийн үнэ.** 2023 оны эхний 3 сард дунджаар 125 ам доллар болж, өмнөх оны дунджаас 3.4 хувиар өслөө. БНХАУ 2021 онд үл хөдлөх хөрөнгийн салбарыг дэмжих чиглэлд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн нь гангийн эрэлтийг дэмжиж, төмрийн хүдрийн үнэ эрчимтэй өссөн. Ирэх онд уг төслүүд хэрэгжиж дууссанаар төмрийн хүдрийн эрэлт саарч, нөгөөтээгүүр Бразил, Австралийн төмрийн хүдрийн нийлүүлэлт нэмэгдсэнээр үнэ буурна.



График 6. Төмрийн хүдрийн үнэ /ам.доллар/




График 7. Нүүрсний үнэ /ам.доллар/тонн/

● **Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ.** 2023 оны эхний 3 сард дунджаар 345 ам доллар болж, өмнөх оны дунджаас 5.0 хувиар буурлаа. 2022 оны 3 дугаар сараас эхлэн ОХУ-ын байгалийн хийн нийлүүлэлт тасалдаж, үнэ өссөнөөр Европт эрчим хүчний хямрал бий болсон. Улмаар Евро бүсийн улсуудад өвөлжилт хүндэрснээр нүүрсний эрэлт нэмэгдэж 2022 онд үнэ өссөн. 2023 онд байгалийн хийн нийлүүлэлт тасалдсан хэвээр байвал нүүрсний эрэлтэд эерэг нөлөө үзүүлнэ гэж Дэлхийн банк үзэж байна. Мөн БНХАУ цар тахлын хөл хориогоо сулруулснаар тус улсын эрчим хүч болон коксжих нүүрсний хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна. Энэ онд нүүрсний үнэ 2022 оны түвшнээс буурах хэдий ч цар тахлын өмнөх түвшнээс өндөр хэвээр байна.

● **Брент газрын тосны үнэ.** 2023 оны эхний 3 сард дунджаар 82 ам.долларт болж, өмнөх оны дунджаас 17.2 хувиар буурлаа. Украинд болж буй дайнаас



График 8. Газрын тосны үнэ /ам.доллар/баррель/

шалтгаалан ОХУ-ын эсрэг авч буй худалдааны хориг арга хэмжээ 2023 онд хэрхэн үргэлжлэх нь тодорхой бус байгаа тул газрын тосны нийлүүлэлтийг төсөөлөхөд хүндрэлтэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт буурч, улс орнуудын инфляцын түвшин өндөр байгаа нь эрэлт талд сөрөг нөлөөтэй.

1.3. Монгол Улсын эдийн засгийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн ДНБ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 52.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 21.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 28.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 хувиар тус тус өслөө.

Эдийн засгийн 2022 оны бодит өсөлтийг салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбар 12.0 хувиар, худалдааны салбар 8.0 хувиар, барилгын салбар 7.9 хувиар, үйлчилгээний салбар 4.9 хувиар, тээврийн салбар 3.0 хувиар тэлсэн нь нийт өсөлтийг дэмжсэн бол уул уурхайн салбар 11.9 хувиар агшсан нь нийт өсөлтийг хязгаарлалаа.

Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн нийт өсөлтийн 1.7 нэгж хувийг бүрдүүлсэн бөгөөд үүний 1.0 нэгж нь суурийн нөлөө байна. Говийн бүсийн аймгуудад 2021 онд хаваржилт хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын гарц, төл бойжилт огцом буураад байсан бол 2022 онд цаг агаар тааламжтай, мал төллөлт сайн байсантай холбоотойгоор тус салбарын үйлдвэрлэл сэргэж, цар тахлын өмнөх түвшнээс 12.0 хувиар өслөө. Мал аж ахуйн салбар 2022 онд 14.5 хувиар өсөж, хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн 92.2 хувийг бүрдүүлсэн бол тариалсан талбайн хэмжээ бага байсантай холбоотойгоор газар тариалангийн салбарын үйлдвэрлэл 11.5 хувиар буурлаа.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн бүтэц /нэгж хувь/

Үзүүлэлт	2019	2020	2021	2022
Эдийн засгийн өсөлт	5.6	-4.6	1.6	4.8
Хөдөө аж ахуй	0.7	0.8	-0.8	1.7
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-0.8
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-1.6
Боловсруулах Цахилгаан дулаан	0.3	0.3	-0.1	0.5
Барилга	0.1	0.0	0.2	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	2.6
Худалдаа	1.2	-1.4	0.6	0.9
Тээвэр	0.2	-1.0	-0.3	0.1
Бусад	1.5	-0.6	1.5	1.6
Цэвэр гатвар	1.0	-1.1	1.3	1.4




График 9. ДНБ-ий өсөлтийн бүтэц /улирлаар/

Уул уурхайн салбарын тухайд 2022 оны сүүлийн хагасаас түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт сэргэсэн хэдий ч БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын нөлөөгөөр оны эхний хагаст хуримтлагдсан уул уурхайн агшилтыг нөхөх түвшинд хүрээгүй байна. 2022 оны эхний хагаст уул уурхайн салбарын ДНБ өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар бага байсан бол зөвхөн сүүлийн хагасын үйлдвэрлэл нь өмнөх оны сүүлийн хагасын үйлдвэрлэлээс 1.2 хувиар нэмэгдсэн. Оюутолгойн баяжмал дахь зэсийн агууламж буурснаар зэсийн баяжмалын үйлдвэрлэл 10.3 хувиар, гадаад эрэлт буурснаар төмрийн хүдрийн олборлолт 26.8 хувиар, боомт дээрх логистикийн саатлаас үүдэлтэйгээр газрын тосны олборлолт 45 хувиар тус тус буурсан нь уул уурхайн салбарын өсөлтийг хязгаарлажээ. Тээврийн салбарын ДНБ сэргэж, 2022 онд 3.0 хувиар өссөн ба үүнд өнгөрсөн оны сүүлийн хагаст хилийн боомтуудын саатал багасаж, нүүрсний экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Цар тахлын нөлөөгөөр агшсан боловсруулах, барилга, худалдаа, үйлчилгээ зэрэг салбарууд 2022 онд сэргэж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 6.3 хувиар өссөн нь төмс, хүнсний ногоо, хувцас, нэхмэлийн үйлдвэрлэлийн гарц нэмэгдсэнтэй холбоотой бол төмөр зам, эрчим хүч, зам талбайн байгууламжид хийгдсэний үр дүнд барилгын салбарын үйлдвэрлэл 7.9 хувиар өсөв. Цар тахлын эсрэг вакцинжуулалтын үр дүнд дотоодын эдийн засгийн үйл ажиллагаа хязгаарлалтгүй байсан нь худалдаа, үйлчилгээний салбаруудын гарц өмнөх оноос нэмэгдэхэд нөлөөллөө.

Эрэлт: Эдийн засгийн нийт эрэлт 2022 онд хүлээлтээс давлаа. Өрхийн хэрэглээ 2022 онд 7.9 хувиар, хөрөнгө 15.5 хувиар нэмэгдсэн нь нийт эрэлтийг дэмжсэн бол цэвэр экспорт 29.3 хувиар буурсан нь сөргөөр нөлөөлсөн байна.

Өрхийн хэрэглээ цар тахлын өмнөх 2019 оны түвшинээс 1.7 хувиар давсан бөгөөд өрхүүдийн нийт хэрэглээ өсөж байгаа хэдий ч Үндэсний статистикийн

хорооны тоон мэдээллээр 2022 онд өрхийн сарын дундаж бодит орлого 0.7 хувиар буурсан байна. Өрхийн бодит орлогод гарсан өөрчлөлтийг байршлаар авч үзвэл Улаанбаатар хотын өрхүүдийн бодит орлого 2.0 хувиар, аймгийн төвийн өрхүүдийнх 7.6 хувиар өссөн бол сумын төвийн өрхүүдийн бодит орлого 6.1 хувиар, хөдөөгийн өрхүүдийнх 15.6 хувиар буурсан байна. Хөдөөгийн өрхүүдийн орлого буурахад мал аж ахуйн орлого 16.6 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн. Мөн 2021 онд хөл хорионы үед иргэн бүрд 300 мянга, вакцинжуулалтын урамшуулал 50 мянган төгрөг зэрэг нэг удаагийн мөнгөн дэмжлэгүүд олгож байсантай холбоотойгоор тэтгэвэр, тэтгэмжийн орлого 2022 онд өмнөх оноос 15.7 хувиар буурсан.

Өрхүүдийн бодит орлого буурахын хажуугаар 2022 онд иргэдийн хадгаламж буурч, зээл нэмэгдсэн. Иргэдийн хадгаламж 2021 оны эхний хагаст 16.9 их наяд төгрөгт хүрч байсан бол 2022 оны эцэст 15.1 их наяд төгрөг болж буурсан. Мөн хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл 2022 онд 9.2 их наяд болж, өмнөх оноос 49.1 хувиар нэмэгдсэн байна.

Хөрөнгийн хуримтлал 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 15.5 хувиар өссөн ба өсөлтийг эргэлтийн хөрөнгө 47.9 хувиар өссөн нь голлон тайлбарлаж байна. Эргэлтийн хөрөнгийг 2021 онд уул уурхайн түүхий эдийн нөөц бүрдүүлж байсан бол 2022 онд төл мал, бэлэн болон дуусаагүй бараа бүтээгдэхүүний нөөц голлон бүрдүүллээ.

Цэвэр экспорт 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 29.3 хувиар буурсан нь эдийн засгийн нийт өсөлтийг 7.8 нэгж хувиар буурууллаа. Бараа, үйлчилгээний импорт 2 дугаар улирлаас хурдтай нэмэгдэж 2022 онд 24.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 30.5 хувиар өслөө. Боомтуудын нэвтрэх урсгал сайжирч, нүүрсний экспорт нэмэгдсэнээр барааны экспорт оны сүүлийн хагаст эрчимжиж, барааны экспорт 12.7 их наяд болж, өмнөх оноос 29.7 хувиар өссөн нь гадаад эрэлтийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг сааруулсан байна.

Инфляц: Жилийн инфляц 2022 оны эцэст улсын хэмжээнд 13.2 хувь гарлаа. Инфляц 2022 оны 6 дугаар сард хамгийн оргилдоо буюу 16.1 хувьд хүрсэн бол сүүлийн хагас жилд аажмаар буурч байна.

Гадаад зах зээлд хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан, гадаад валютын албан нөөц өссөн зэргээс шалтгаалан оны сүүлийн саруудад инфляцын түвшин буурсан хэдий ч Монголбанкны зорилтот түвшнээс хоёр дахин өндөр хэвээр байна.

Зураг 1. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Засгийн газраас гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнд валютын зах зээл тогтворжиж, төгрөгийн сулрах дарамт буурснаар импортын барааны үнэ буурах хандлага ажиглагдаж эхэлсэн бол махнаас бусад дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байна.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2022 онд өмнөх оноос 6.5 хувиар өсөж, 29.7 их наяд төгрөгт хүрэхэд валютын харилцах 2.1 дахин, валютын хадгаламж 23.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Мөнгөний нийлүүлэлтийг эх үүсвэр (актив) талаас нь авч үзвэл дотоодын зах зээлийн зээл олголт дэмжсэн бол гадаад цэвэр актив буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг саарууллаа.

Зураг 2. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)




Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь)



Арилжааны банкуудын зээл 2022 онд 6.5 хувь өссөний 3.2 нэгжийг хэрэглээний, 2.3 нэгжийг хувийг ипотек, 3.1 нэгжийг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын зээл бүрдүүлжээ. Арилжааны банкуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 оноос 2022 оны эхний хагас хүртэл буурсан боловч 3 дугаар улиралд гадаад секторын идэвхжил саарсантай холбоотойгоор эрс өссөн. Харин Засгийн газраас гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр уул уурхай, худалдаа зэрэг салбаруудын чанаргүй зээл буурч, улмаар нийт зээлийн чанар сайжирсан байна.

Зураг 4. Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн

Зураг 5. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж. Монголбанк

Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Ковид-19 цар тахал Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд сэргөөр нөлөөлж 2020 оны 4 дүгээр улиралд хөл хорио тогтоосноор ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт мэдэгдэхүйц буурсан. Сүүлийн улирлуудад дотоодын эдийн засаг алгуур идэвхжиж, хөдөлмөрийн зах зээл сэргэх хандлагатай байгаа ч ажиллагсдын тоо цар тахлын өмнөх түвшнээс доогуур хэвээр, өсөлтийн хурд саарч байна. Ажиллагсдын тооны өсөлтөд боловсруулах үйлдвэрлэл, тээвэр агуулах, уул уурхай, хөдөө аж ахуй, худалдааны

Зураг 6. Улирлын нөлөөг арилгасан ажиллагсдын тоо (мянган хүн)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

салбарын ажил эрхлэлт эергээр нөлөөлөв.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 57.9 болж өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар, цар тахлын өмнөх түвшнээс 2.8 нэгж хувиар тус тус доогуур байна. Ажиллах хүчний оролцоо цар тахлын өмнөх түвшнээс доогуур байгаа нь цар тахлын үед иргэд тэтгэвэрт гарч, хөдөлмөрийн зах зээлийг орхих үзэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байж болзошгүй. Ажиллах хүчнээс гадуурх хүн амд тэтгэвэр, тэтгэмж авагчдын эзлэх хувийн жин 2018 оны мөн үеэс 4.8 нэгж хувиар (62.5 мянган хүн) нэмэгдсэн байна.

Дотоодын эдийн засаг сэргэж 2022 онд 4.8 хувиар өссөн ч иргэдийн ажиллах хүчний оролцоо нэмэгдэхгүй, ажилгүйдлийн түвшин 5.3 хувьд хүрч дунджаас 2.8 нэгж хувиар доогуур байгаа нь хөдөлмөрийн зах зээлд ажилтан олдохгүй, хомсдол үүсэж болзошгүйг харуулж байна.

Зураг 7. Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Зураг 8. Ажилгүйдлийн түвшин (хувь)




Сүүлийн жилүүдэд насанд хүрэгчдийн боловсролын түвшин дээшилсээр байгаа ч боловсролын чанар сул байна. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой иргэдийн ажиллах хүчний оролцоо бүрэн дунд болон бага ба түүнээс доош боловсролтой иргэдийн оролцооноос ердөө 2 нэгж хувиар дээгүүр байна. Мөн Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд (2016-2020) дурдсанаар мэргэжлийн болон техникийн боловсрол (МБТБ) төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь их, дээд сургууль төгсөгчдөөс доогуур байна. Мэргэжлээрээ ажиллаагүй төгсөгчдийн 41.0 хувь нь ажлын байр хомс гэсэн шалтгааныг дурдсан бөгөөд мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэх байдал мэргэжлийн чиглэлээр харьцангуй ялгаатай байгаа нь дээд боловсролын бэлтгэж буй мэргэжлийн чиглэл хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

Зураг 9. Ажиллах хүчний оролцооны түвшин (боловсролын түвшин, хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Зураг 10. Мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлт (МБТБ төгсөгчид, хувь)




Эх сурвалж: Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, 2020 он, ХНХСИ

2022 онд инженер, архитектур, байгалийн ухаан чиглэлээр 11.8 мянган хүн төгссөн бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн 62 хувийг хангахаар байгаа бол бизнес, удирдлага, эрхзүйн чиглэлээр 11.1 мянган хүн бэлтгэгдэж төгссөн ч хөдөлмөрийн зах зээлийн эрэлтээс даруй 7 дахин их

байгаа нь дээд боловсролын бэлтгэж буй мэргэжлийн чиглэлийг хөдөлмөр зах зээлийн эрэлттэй нийцүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Зураг 11. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт (мянган хүн, 2022 он)



Эх сурвалж: ХЗЗ-ийн эрэлтийн барометрийн судалгаа. ХНХСИ, БШУЯ

Зураг 12. Нэг ажилтанд ногдох капитал ба бүтээгдэхүүний өсөлт (хувь)



Эх сурвалж: Пенний дэлхийн хүснэгт

Нэг ажилтанд ногдох капиталын хэмжээ 1990-ээд оноос бараг өөрчлөгдөөгүй байгаагаас үзэхэд хөдөлмөрийн бүтээмж капиталын гүнзгийрэлтээс шалтгаалж өсөөгүй, харин технологийн өөрчлөлт, хөдөлмөрийн хуваарилалтаас үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хэрэв нэг ажилтанд ногдох капитал ялангуяа уул уурхайн бус салбарт нэмэгдвэл хөдөлмөрийн бүтээмж мөн нэмэгдэх боломжтой.

Гадаад худалдаа: Монгол Улс 2022 онд 162 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21.2 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 32.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар өсөж 12.5 тэрбум ам.долларт хүрэхэд нүүрсний экспорт 135.5 хувиар буюу 3.7 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Түүнчлэн хаагдаад байсан Шивээхүрэн боомт 2022 оны 5 дугаар сараас нээгдэж, 7 дугаар сараас эхлэн Гашуунсухайт боомтод автомат удирдлагатай тээвэрлэлтийг (AGV) нэвтрүүлж, битүүмжилсэн тээврийн багийн үйл ажиллагаа жигдэрсэн нь нүүрсний экспорт өсөх гол шалтгаан болов. Импортоор 2022 онд 8.7 тэрбум ам долларын бараа худалдан авсан нь өмнөх оноос 25.2 хувиар их байв. Дээрх өсөлтийн 14.1 нэгж хувийг үнийн өөрчлөлт, 11.1 нэгж хувийг биет хэмжээний өөрчлөлт бүрдүүлжээ.

Дэлхийн томоохон дизель түлш экспортлогч АНУ дизель түлшний хомсдолд орсон, Украин дахь дайнтай холбоотойгоор ОХУ-ын дизель түлш, улаан буудайн экспорт удааширснаар дизель түлш болон гурил, түүнийг дагасан хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн нь импортын үнийн өсөлтөд голлон нөлөөлөв. Харин ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшуулсан, цар

тахлын дараа үйлчилгээний газрууд бүтэн цагаар ажиллах болсон зэрэг нь хэрэглээний импортын биет хэмжээний өсөлтийг дэмжлээ.

Төлбөрийн тэнцэл: БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогоос шалтгаалсан хил, гаалийн саатлаас үүдэлтэй экспортын бууралт, өмнөх онд урьдчилж борлуулсан нүүрсний экспорттой холбоотой экспортын бодит орлогын тасалдал болон импортын өсөлтөөс шалтгаалан 2022 онд төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байв. Өнгөрсөн оны эхний 3 улиралд төлбөрийн тэнцлийн алдагдал тасралтгүй нэмэгдсэн ч Засгийн газраас авч хэрэгжүүлсэн экспортын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд 2022 оны сүүлийн улиралд худалдааны тэнцэл ашигтай гарч, төлбөрийн тэнцлийн алдагдлыг хязгаарлалаа. “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд валютын орлого төвлөрүүлэх, экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, хяналтыг сайжруулах, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн гэрээг ил тод болгох чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.


Улмаар 2022 оны эхний 3 улиралд 1.4 тэрбум ам.долларт хүрээд байсан төлбөрийн тэнцлийн алдагдал оны эцэст 0.7 тэрбум ам.долларт хүрч буурлаа. Урсгал дансны алдагдал 2022 онд өмнөх оноос 0.5 тэрбум ам.доллараар нэмэгдэж 2.7 тэрбум ам.долларт хүрсэн бол санхүүгийн дансны ашиг 2.0 тэрбум ам.доллар буюу өмнөх оны түвшинд байв. Шууд хөрөнгө оруулалтын дансны ашиг өмнөх оноос 0.4 тэрбум ам.доллараар бага буюу 1.6 тэрбум ам.доллар байсан ч худалдааны зээлийн данс цэвэр дүнгээр 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь санхүүгийн дансны ашиг өмнөх оны түвшинд хүрэхэд голлон нөлөөллөө. Өнгөрсөн оны 1 дүгээр сард “МИК ОССК” ХХК 2019 онд олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалсан 300 сая ам.долларын бондын үлдэгдэл төлбөрийг төлсөн бол 2022 оны эцэст Монгол Улсын Засгийн газар Чингис бондын үлдэгдэл 136.8 сая ам.долларыг амжилттай төлж барагдууллаа.

График 10. Төлбөрийн тэнцэл
(сая ам.доллар)

График 11. ГВАН, хүрэлцээт түвшин
(сая ам.доллар, сар)



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк, тооцоолол

Төлбөрийн тэнцлийн алдагдал өндөр байсантай холбоотойгоор гадаад валютын албан нөөц 2022 оны 8 дугаар сарын дунд 2.4 тэрбум ам.долларт хүрч буураад байсан ч 2022 оны эцэст 3.4 тэрбум ам.доллар болж нэмэгдлээ.

1.4. Эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл


ДНБ: Үндэсний статистикийн хорооны урьдчилсан тооцоогоор эдийн засгийн өсөлт 2023 оны эхний 2 сарын байдлаар 8.1 хувь байна. Экспортын бүтээгдэхүүний гэрээнүүд болон олборлолтоос экспорт хүртэлх бүх шатны худалдан авалтын мэдээллийг цахим системд бүртгэлжүүлж, экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэх зорилтыг хангаснаар 2023 онд уул уурхайн болон тээврийн салбар тус тус 15 орчим хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжихээр байна. Мөн Оюутолгойн далд уурхайн үйлдвэрлэл, газрын тос боловсруулах үйлдвэр, авто болон төмөр зам, боомт, эрчим хүчний томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжиж, барилгын салбарын өсөлтийг дэмжихээр байна. Харин оны эхэнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, Увс, Архангай, Завхан, Сүхбаатар, Говь-Алтай, Хэнтий аймгуудад малын зүй бус хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарахаар байна. Эдийн засгийн өсөлт жилийн эцэст 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 оны эхний 3 сарын байдлаар 5.7 тэрбум ам доллар болж өмнөх оны мөн үеэс 57.8 хувиар өслөө. 2023 оны жилийн эцэст 22.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 3.4 орчим тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын үр дүнд нүүрсний экспорт 45 сая тоннд хүрч, нийт экспорт 12.8 орчим тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Хөл хорио цуцлагдсантай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний биет хэмжээ, геополитикийн тогтворгүй байдлаас шалтгаалан нефтийн бүтээгдэхүүний

болгосноор тус салбарын гарц нэмэгдэж, улмаар уул уурхайн бус салбарууд нийт эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.


Харин 2025 онд эдийн засаг 6.5 хувиар, 2026 онд 5.4 хувиар өсөхөөр төсөөлж байна. Нүүрсний экспорт, Оюутолгойн баяжмалын үйлдвэрлэл, зэс болон алтны агууламж нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт 2025 онд эрчимжиж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжих бол 2026 онд уул уурхайн салбарын өсөлт өмнөх оны суурийн нөлөөгөөр саарахаар төсөөлж байна. Дунд хугацаанд “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилга, боловсруулах салбар болон бусад салбаруудын өсөлт цар тахлын өмнөх хэвийн түвшинд тогтворжихоор байна.

График 12. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ (хувь, их наяд төгрөг)



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

График 13. Гадаад худалдаа (сая ам.доллар)



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Гадаад худалдаа: Засгийн газраас экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэх, олборлолт, тээвэрлэлт, борлуулалтыг сайжруулж экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулж, баяжмалын шинжилгээний тогтолцоог шинэчлэх, хүнээс хамааралгүй, ил тод болгох, олборлолтын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, түүхий эдийн борлуулалтыг уул уурхайн биржээр дамжуулан зах зээлийн ил тод тогтолцоонд шилжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Хилийн боомт орчмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, экспортын бүтээгдэхүүний борлуулалт, төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг ил тод болгосноор экспортын хэмжээ тогтворжихоор байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын материал, автобензин, дизель түлш, үйлдвэрлэлийн орц, машин, механизм, тэдгээрийн эд ангийн импорт өсөх төлөвтэй байна. 2024 онд экспорт 14.1 тэрбум ам доллар, импорт 9.9 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна.

Дунд хугацаанд зэсийн үнэ тогтвортойгоор нэмэгдэж байгаагаас гадна Оюу толгойн далд уурхай ашиглалтад орсноор экспортод гарах зэсийн

баяжмалын хэмжээ нэмэгдэх төлөвтэй байна. Засгийн газраас "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэн "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг батлан хэрэгжүүлж байна. Тус бодлогын нөлөөгөөр хилийн боомт орчмын дэд бүтэц сайжирч, экспортын хүчин чадал нэмэгдэхээр байгаа бол бүтээн байгуулалтын хөтөлбөрүүдийн нөлөөгөөр импортын биет хэмжээ өсөхөөр төсөөлж байна. Дунд хугацаанд барилгын материал, автобензин, дизель түлш, үйлдвэрлэлийн орц, машин, механизм, тэдгээрийн эд ангийн импорт өсөх төлөвтэй байна. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2025-2026 онд дунджаар 4.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Инфляц: Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсөв, мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж байна. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын бодит орох урсгалыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын ханшийн зах зээл тогтворжих хандлагатай байна. Эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнд инфляцын түвшин дунд хугацаанд буюу 2024-2026 онд Монголбанкны зорилт болох +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд байхаар хүлээгдэж байна.

1.6. Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл

Нэг. Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах: Геополитикийн тогтворгүй нөхцөл байдал улам хурцдах, үнийн өсөлт үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байх зэрэг хүчин зүйлс дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн инфляцыг бууруулахад чиглэсэн томоохон эдийн засгуудын мөнгөний хатуу бодлого хөгжиж буй орнуудад санхүүжилт босгоход нь хүндрэл учруулах эрсдэл хэвээр байна.

АНУ, Швейцарт үүссэн санхүү, эдийн засгийн савлагаа үргэлжилж, олон улсын хөрөнгийн зах зээлээр дамжин дэлхийн бодит эдийн засгийн идэвхилийг хязгаарлаж болзошгүй байна. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах зэрэг сүвгуудаар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Хоёр. Эрчим хүчний хангамж: Эрчим хүчний хангамж, хүртээмж, найдвартай байдал, үр ашигтай зохион байгуулалт нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хэдий ч манай улсын төвлөрсөн эрчим хүч, дулааны хангамжийн систем нь өнөөгийн хурдацтай өсөж буй эрэлтийг хангаж чадахгүй байна. Түүнчлэн эрчим хүчний суурилагдсан хүчин чадал төдийлөн нэмэгдээгүйгээс гадна станцууд¹ 35-60 жил, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ 32-62 жилийн насжилтай байгаа нь хүчин чадлаасаа давсан

¹ Амгалан дулааны станцаас бусад

үйлдвэрлэл явуулж байгаа өнөө үед оргил ачааллын үеэр гэмтэл гарч, нийлүүлэлтийн тасалдалд хүргэх эрсдэл өндөр байна. Энэ нь улмаар бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

Гурав. Малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл: Хөдөө аж ахуйн салбар нь байгаль, цаг уурын нөхцөл байдалтай шууд хамааралтай бөгөөд Монгол орны цаг агаарын дундаж температур 1940 оноос хойш жилд дунджаар 2.2 градусаар нэмэгдэж байна. Цаг агаарын таагүй байдал, халдварт өвчин тархалт нь хөдөө аж ахуй салбарын нийлүүлэлтэд нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, өрхүүдийн бодит орлогыг бууруулах, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэл байна. Өнгөрсөн онд хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас бага байсан, нийт нутгийн 60 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн, өвөлжилт хүндрэлтэй байсантай холбоотойгоор хаваржилт хүндрэх төлөвтэй байна. Мөн хөдөөгийн өрхийн орлогын 38 хувийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд малын зүй бус хоргодол өндөр, малын гоц халдварт өвчний тархалт их болох нь өрхийн орлогыг бууруулж, ажилгүйдлийн түвшин, тэгш бус байдал, Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Дөрөв. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитик, цар тахлын хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурах, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх нь чухал байна. Иймд, манай улс олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, харилцан ойлголцож, зээлжих зэрэглэл тогтоох болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх шаардлагатай. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.


2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хүснэгт 2. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл /тэрбум төгрөгөөр/


Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2024	2025	2026
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ	6.5	6.5	5.4
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	6.0	6.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	21,163.2	22,472.0	24,089.6
ДНБ-д эзлэх хувь	32.3	30.9	30.4
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	22,996.1	23,928.8	25,676.6
ДНБ-д эзлэх хувь	35.1	32.9	32.4
5 Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	2,520.8	932.7	1,747.8
ДНБ-д эзлэх хувь	3.9	1.3	2.2
6 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум	-1,832.9	-1,456.8	-1,587.0
ДНБ-д эзлэх хувь	-2.8	-2.0	-2.0
7 Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ	5,850.4	6,145.6	6,406.0
ДНБ-д эзлэх хувь	8.9	8.4	8.1
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр	39,276.0	43,704.0	47,610.0
ДНБ-д эзлэх хувь	60.0	60.0	60.0
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ	2,153.8	2,241.6	2,305.9
ДНБ-д эзлэх хувь	3.3	3.1	2.9

3. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.


 **Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутам 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутам 182.5 ам.доллар байна.

 **Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшнийг баримталлаа.


Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл /ДНБ-д эзлэх хувь/

	2024	2025	2026
Хуулийн хязгаар	-2.8	-2.0	-2.0
Төсөөлөл	-2.8	-2.0	-2.0

 **Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь.** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 онд 12.3 хувиар өсөх, 2024 онд 4.1 хувиар өсөх, 2025 онд 7.3 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл /хувь/

Өсөлт	2024	2025	2026
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	12.3	4.1	7.3
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	9.7	8.8	9.1
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	12.8	11.0	10.3

 **Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй

байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2024-2026 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 5. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр /ДНБ-д эзлэх хувь/

	2024	2025	2026
Хуулийн хязгаар	60.0	60.0	60.0
Төсөөлөл	60.0	60.0	60.0

4. ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ

4.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл

4.1.1. Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18,593.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 11.3 хувиар буюу 1,886.9 тэрбум төгрөгөөр давсан байна.

Үзүүлэлт	2020 гүйц	2021 гүйц	2022 у.гүйц
Нийт орлого	10,444.2	14,306.4	18,593.1
Тогтворжуулалтын сан	66.2	627.9	1,394.6
Ирээдүйн өв сан	914.1	967.0	-
Тэнцвэржүүлсэн орлого	9,463.8	12,711.4	17,198.5
Татварын орлого	8,511.6	11,299.9	15,568.3
Татварын бус орлого	952.2	1,411.5	1,630.2

4.1.2. Төсвийн зарлага

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18,833.8 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 18,177.8 тэрбум төгрөгийн буюу 96.5 хувийн, улсын төсвийн зарлага 11,572.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 11,345.8 тэрбум төгрөгийн буюу 98.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 6. 2022 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын урьдчилсан гүйцэтгэл, томсгосон ангиллаар /тэрбум төгрөг/

Төсвийн төрөл	Нийт зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал				Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл
		Цалин хөлс	БҮ-ний бусад	Зээлийн хүү	Татаас, шилж.		
Нэгдсэн төсөв	18,177.8	1,656.6	2,104.9	816.4	9,634.3	3,813.2	152.5
Улсын төсөв	11,345.8	1,321.6	1,323.6	791.9	4,996.8	2,770.4	141.5
ОН-ийн төсөв	2,920.4	310.0	869.1	24.6	651.0	1,042.7	23.0
НДС	3,408.7	20.6	9.5	0.0	3,383.2	0.0	-4.6
ЭМДС	1,472.8	4.5	48.7	0.0	1,426.9	0.0	-7.3
Ирээдүй өв сан	1,488.1	0.0	0.0	0.0	1,488.1	0.0	0.0

4.2. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл

4.2.1. Төсвийн орлого

Энэ оны эхний улирлын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогын гүйцэтгэл 5.1 их наяд төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 193.6 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Хүснэгт 7. 2023 оны Нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.3 Төл	2023.3 Гүйц.	2023 ХБГ
Нийт орлого	4,879.4	5,073.0	21,341.2

Тогтворжуулалтын сан	23.7	278.0	582.7
Тэнцвэржүүлсэн орлого	4,855.8	4,794.8	20,277.0

Төсвийн нийт орлого 2023 онд 21.3 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 20.3 их наяд төгрөг байхаар хүлээгдэж байна. Энэ онд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн Боомтын сэргэлтийн ажлыг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд эхний улирлын байдлаар эрдэс бүтээгдэхүүний экспорт өсөж, нүүрсний экспорт 14.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 11.6 сая тонноор нэмэгдсэн байна.

4.2.2. Төсвийн зарлага

Төсвийн нийт урсгал зардал 2023 онд 15.2 их наяд төгрөг ба үүний 25.9 хувь нь төрөөс иргэдэд олгодог нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 24.9 хувь нь төрийн албан хаагчдад олгох цалин хөлс, 15.1 хувь нь төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой урсгал зардал, 9 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж, 9.5 хувь нь төрөөс иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлт, чөлөөлөлт, 11.9 хувь нь татаас, гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 3.7 хувь нь гүйцэтгэлээр санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын урсгал зардал тус тус эзэлж байна.

Энэ оны эхний улирлын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 4.1 их наяд төгрөг буюу 77.8 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 8. 2023 оны Нэгдсэн төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл

Үзүүлэлт	2023 Бат	2023.3 Төсөв.	2023.3 Гүйц.
Нийт Зарлага	20,475.3	5,319.2	4,138.2
Урсгал зардал	15,247.5	4,468.8	3,669.7
Хөрөнгийн зардал	5,359.7	866.6	488.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-132.0	-16.2	-19.5

4.3. Нэгдсэн төсвийн үзүүлэлт

Хүснэгт 9. Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021 Гүйц	2022 Урьд. гүйц	2023 Бат	2024 ТХМ
Төсвийн нийт орлого	14,306.4	18,593.1	19,722.3	24,103.4
Тэнцвэржүүлсэн нийт орлого	12,711.4	17,198.5	19,049.6	21,163.2
Төсвийн нийт зарлага	15,630.4	18,177.8	20,475.3	22,996.1
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,919.0	-979.3	-1,425.7	-1,832.9
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>-6.8</i>	<i>-1.9</i>	<i>-2.6</i>	<i>-2.8</i>

5. Монгол Улсын 2024-2026 оны нэгдсэн төсвийн төсөөлөл

5.1. Монгол Улсын 2024-2026 оны нэгдсэн төсвийн бодлого

Монгол Улс цар тахлын болон геополитикийн хямралын дараах эдийн засгийг эрчимжүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримтална.

Нэг. Төсвийн зарлагыг хэмнэлттэй, үр ашигтай хуваарилах зарчим баримталж дунд хугацааны хөгжлийн бодлого-Шинэ сэргэлтийн бодлогын зорилт, арга хэмжээг дэмжихэд чиглүүлнэ:

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийгмийн суурь үйлчилгээний салбарт эхлүүлсэн гүйцэтгэл, үр дүнд чиглэсэн санхүүжилтийн шинэчлэлийг бусад салбарт нэвтрүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- Нийгмийн болон дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтаар дамжуулан хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжинэ.
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

Хоёр. Төрийн хэмнэлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд ил тод байдлыг сайжруулах, хяналт ба хариуцлагыг чангатгана.

Гурав. Төсвийн орлого болон татварын бодлогын хүрээнд:

- Хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж экспорт, импортын нийлүүлэлтийн сувгийг эрчимжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- Мэдээллийн технологид суурилан бүх шатны татварын болон гаалийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулж, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх татварын үйлчилгээг цахимжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- Эрсдэлтэй салбаруудыг тодорхойлж, тэдгээрийг татварын бүртгэлд хамруулах, тайлагнуулах замаар далд эдийн засгийг бууруулна. Татвараас зайлсхийхийн эсрэг болон мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагаатай холбогдох олон улсын стандартыг татварын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн мөрдөнө.

Дөрөв. Эдийн засгийг тогтворжуулах хүрээнд:

- Инфляцын дарамтыг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангана.
- Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлнэ.

5.2. Монгол Улсын 2024-2026 оны төсвийн орлогын төсөөлөл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 онд 24.1 их наяд төгрөг болж, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр тооцлоо. Үүнд, тэнцвэржүүлсэн орлого 21.2 их наяд төгрөг, Ирээдүйн өв сангийн орлого 2.4 их наяд төгрөг, Тогтворжуулалтын сангийн орлого 0.5 их наяд төгрөг байхаар тооцооллоо.

Хүснэгт 10. Төсвийн нийт орлогын дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 төс	2025 төс	2026 төс
Тэнцвэржүүлсэн орлого	21,163.2	22,472.0	24,089.6

Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд экспортын шинэ гарцыг бий болгох замаар, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана. Тухайлбал, БНХАУ-ын талтай хийх яриа хэлэлцээрийг эрчимжүүлж, Гашуунсухайт-Ганцмод чиглэлээр шинэ гарц нэмэх, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн квотыг нэмэгдүүлнэ.

Уул уурхайн салбар, түүнийг дагасан бусад салбарын орлого нэмэгдүүлэх хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тодорхой стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн татвар хураалтын менежментийг сайжруулж, татвар ногдуулах, хураах, хяналт тавих үйл ажиллагаанд мэдээллийн технологи түлхүү ашиглах замаар их хэмжээний татварын өр төлбөр үүсэхээс сэргийлэх, татвар хураалтыг сайжруулах замаар хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ. Мөн татвар төлөгчтэй хамтран ажиллаж, шаардлагатай зөвлөмж өгөх үйлчилгээг үзүүлж, тэднийг татварын эрсдэлд орохоос сэргийлнэ.

5.3. Монгол Улсын 2024-2026 оны төсвийн урсгал зардлын чиглэлээр баримтлах бодлого

Төсвийн урсгал зардлыг хэмнэлттэй, үр ашигтай хуваарилах зарчим баримталж дунд хугацааны хөгжлийн бодлого-Шинэ сэргэлтийн бодлогын зорилт, арга хэмжээг дэмжихэд чиглүүлнэ.

Дунд хугацаанд төсвийн суурь зарлага буюу хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн үр дүн, үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийж тодорхойлсны үндсэн дээр Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд нэмэлт эх үүсвэрийг хуваарилах бодлого баримтална.

Төрийн хэмнэлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд ил тод байдлыг сайжруулах, хяналт ба хариуцлагыг чангатгана.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийгмийн суурь үйлчилгээний салбарт эхлүүлсэн гүйцэтгэл, үр дүнд чиглэсэн санхүүжилтийн шинэчлэлийг бусад салбарт нэвтрүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ. Ингэхдээ урт, дунд болон богино хугацааны бодлого стратегийн зорилт, хүрэх үр дүнг төсвийн процесстой уялдуулж төлөвлөлт-төсөвлөлт-хяналт-тайлагналын нэгдсэн удирдлагыг дэмжих тогтолцоог бий болгоно.

Иргэдийн орлогын баталгааг нэмэгдүүлэх хүрээнд эдийн засгийн өсөлттэй уялдуулж хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Хүснэгт 11. Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 төс	2025 төс	2026 төс
Нийт зарлагын дээд хэмжээ	22,996.1	23,928.8	25,676.6

5.4. Төсвийн хөрөнгө оруулалт, бодлого зарчим, хүрэх үр дүн

5.4.1. Төсвийн хөрөнгө оруулалт 2018-2023 он

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2023 онд 10.5 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2018-2022 онд 6.7 наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бол 2023 онд хамгийн өндөр төсвийн хөрөнгө оруулалт буюу 2.9 их наяд төгрөгийн 1,141 төсөл хэрэгжиж байгаагаас 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 349.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор гүйцэтгэл 11.8-тай байна.




Хүснэгт 12. УТХО-ын 2023 оны гүйцэтгэл /2023.04.10-ны өдрийн байдлаар/

АНГИЛАЛ	Төслийн тоо	Үүнээс : 2023 онд дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Нийт гүйцэтгэл	Гүйц. хувь	Үлдэгдэл санхүүжилт
УЛСЫН ТӨСӨВ	1137	881	7,385,246.2	2,695,015.3	349,387.9	12.96	2,345,627.4
КОНЦЕС СЭРГЭН ТӨЛӨЛТ	4	4	541,524.7	279,590.4	547.0	0.20	279,043.4
НИЙТ	1141	885	7,926,770.9	2,974,605.7	349,934.9	11.76	2,624,670.8

5.4.2. Төсвийн хөрөнгө оруулалт 2024-2026 он

Жилд дунджаар ДНБ-ний 4-тэй тэнцэх хэмжээний улсын төсвийн хөрөнгө оруулалт батлагдаж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ДНБ-д эзлэх дундаж хувиар тооцож үзвэл:



5.4.3. 2024 онд баримтлах бодлого, шалгуур үзүүлэлт

Төсвийн хөрөнгө оруулалтын оновчтой, үр дүнтэй байдал нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил болоод хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх чухал нөлөөтэй байдаг. Тийм ч учраас төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэлийн хүрээнд эрэлт хэрэгцээнд нийцсэн, нийгмийн ач холбогдолтой, эдийн засгийн үр ашиг бүхий төслүүдийг төсөвт тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны бодлогын хувьд эхлүүлсэн төслүүдээ дуусгах, шинэ төсөл эхлүүлэхгүй байх, барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилтийг бүрэн олгох болон гадаадын зээл тусламжийн төслүүдийн монголын талын хариуцах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зарчим баримталсан, үүний хэрэгжилтийг зохион байгуулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх анхны жил бөгөөд цахим, ил тод, хэмнэлттэй байх зарчмыг баримталж байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын хувьд дараах бодлого, шалгуур үзүүлэлтийг баримтална. Үүнд:

- Нийгмийн болон дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтаар дамжуулан хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжинэ.
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр хооронд оновчтой хуваарилалт, тохируулга хийснээр нэн шаардлагатай төслүүдийг санхүүжүүлнэ.
- Иргэдийн оролцоонд суурилсан ил тод, цахим, хэмнэлттэй бөгөөд үр ашигтай төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлнэ.



5.5. Гадаад зээл, тусламжийн ашиглалт, баримтлах зарчмууд

Монгол Улсын дунд хугацааны гадаад зээл, тусламжийн ашиглалтын төсөөллийг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого чиглэлтэй уялдуулан дараах зарчмыг үндэслэн төлөвлөлөө. Үүнд:

Нэг. Зээл, тусламжийн хөрөнгөөр эхлэн хэрэгжих төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлого чиглэлд туссан, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилттой уялдсан байх. Шинээр эхлэх төсөл болон хэлэлцээрийн шатандаа байгаа төслийг “Шинэ сэргэлтийн бодлого” болон хөгжлийн бусад бодлого хөтөлбөртэй уялдуулах бөгөөд энэ хүрээнд Чойр-Сайншандын, Эрдэнэбүрэн Мянгад-Улиастай чиглэлийн, Багануур-Чойрын, Сайншанд-Цагаан суваргын болон Мандалговь-Арвайхээр чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслүүд, Аюулгүй, шуурхай худалдааг дэмжих уян хатан, нэгдсэн хилийн үйлчилгээ байгуулах төсөл зэрэг томоохон төслүүдийг шинээр эхлүүлнэ.

Хоёр. Зээл, тусламжийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжиж дуусах төслүүдийн хувьд санхүүжилтийг бүрэн олгож, хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлийг баримтлах ба мөн төсөл, арга хэмжээ нь удаашралтай байгаа төслүүдийг хойшлуулах, эх үүсвэрийг үр дүнтэй хэрэгжиж буй төслийн санхүүжилтэд шилжүүлэх чиглэлээр ажиллах. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хилийн боомт, зам тээвэр, эрчим хүч, усан хангамж, экспорт, үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүдийг гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэн тэргүүнд санхүүжүүлнэ.

Гурав. Хөгжлийн бодлогод туссан тэргүүлэх ач холбогдолтой шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж, нийт санхүүжилтийн 50 орчим хувийг зарцуулах бөгөөд тус хөрөнгийн 70 орчим хувийг Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, Газрын тос боловсруулах үйлдвэр барих болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барих зэрэг томоохон төслүүдэд зарцуулахаар төлөвлөж байна.


6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ

6.1. Засгийн газрын өр

6.1.1. Улсын нийт гадаад өр


Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 33.6 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 21.8 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 8.0 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 2.2 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.6 тэрбум ам.долларыг арилжааны банкуудын өр тус тус эзэлж байна.

График 14. Улсын нийт гадаад өрийн статистик 2018-2022* /тэрбум доллар/



Улсын нийт гадаад өрийг зээлдүүлэгч тус бүрээр харуулбал Олон зээлдүүлэгч оролцсон зээллэгийн үлдэгдэл 14.4 тэрбум ам.доллар, Нидерландын Хаант Улсын 8.8 тэрбум ам.доллар, БНХАУ-ын 3.7 тэрбум ам.доллар, Япон Улсын 1.5 тэрбум ам.доллар, Бүгд Найрамдах Сингапур Улсын 1.1 тэрбум ам.доллар, бусад улсын 3.8 тэрбум ам.доллартой тэнцэж байна.

График 15. Улсын нийт гадаад өр, зээлдүүлэгчээр /2018-2022*/



6.1.2. Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 31.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 52.4 хувьтай тэнцэж байна.


Хүснэгт 13. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2022*
I. Засгийн газрын дотоод өр		1,035.5
1.1	Үнэт цаас	1,035.5
II. Засгийн газрын гадаад өр		29,641.1
2.1	Үнэт цаас	9,359.8
2.2	Зээл	20,281.8
III. Засгийн газрын бусад өр		1,287.7
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	811.8
3.2	"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	463.5
3.3	Орон нутгийн зээллэг	12.3
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		31,964.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		27,726.6
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		70.0 %
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		52.4 %

*Урьдчилсан гүйцэтгэлээр

6.1.3. Засгийн газрын өрийн тухай тусгай шаардлага

График 16. Засгийн газрын өрийн хязгаар /2021-2026/



Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2024 онд 60 хувиас хэтрэхгүй байхаар заасан байдаг. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа суурь төсөөллөөр 2023 онд 51.2 хувь, 2024 онд 49.0 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна.

Улсын Их Хурлын 2022 оны 68 дугаар тогтоолын дагуу МУХБ-ны олон улсын зах зээлд дахин санхүүжүүлэх зорилгоор гаргах үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгааг шаардлагатай тохиолдолд гаргахад 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 54.3 хувьтай, 2024 онд 51.9 хувьтай тэнцэхээр төсөөлөлтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарт нийцэж байгаа юм.

6.1.4. Засгийн газрын гадаад зээл


Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2022 оны хооронд нийт 7,685.2 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчийн 326 төсөл хөтөлбөрт зарцуулсан байдаг. Үүнээс 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 1,886.7 сая ам.долларыг эргэн төлж 5,798.5 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

Энэхүү гадаад зээлийн хөрөнгийг төслийн зээлийн хүрээнд 5,002.0 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,685.2 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг авч ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад төслийн зээлийн хувьд 2,332.6 сая ам.доллартой тэнцэх эх үүсвэрийг дэд бүтцийн буюу зам, тээвэр, эрчим хүч, орон сууц, нийтийн аж ахуйн салбаруудад, 1,461.8 сая ам.доллартой тэнцэх эх үүсвэрийг эргэлтийн хөрөнгө буюу жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл, барааны зээл, банк, санхүүгийн салбаруудад зарцуулсан бол үлдсэн 1,207.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг нийгмийн шинж чанартай

төсөл, арга хэмжээнүүд болох эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал зэрэг салбаруудад ашигласан байна.

График 17. Гадаад зээлийн ашиглалтыг зориулалтаар /2022.12.31/



Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 46.6 хувийг дэд бүтцэд, 29.2 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 24.1 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 86.8 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 13.2 хувийг уул уурхай, эрчим хүчний салбарууд тус тус эзэлж байна.

6.1.5. Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 9,359.8 тэрбум төгрөг буюу 2,717.3 сая ам.доллартой тэнцэж байна.

Хүснэгт 14. Гадаад үнэт цаас, 2022.12.31-УГ /тэрбум төгрөг/


№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл
1	Хуралдай	8.750	7 жил	2,066.8
2	Гэрэгэ	5.625	5.5 жил	1,781.7
3	Номад	5.125	5.5 жил	2,066.8
4	Сенчири-2027	3.500	6 жил	1,722.3
5	Сенчири-2031	4.450	10 жил	1,722.3
НИЙТ				9,359.8

Засгийн газар нь 2023 онд өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын байр сууриас шалтгаалан шинээр хийх өрийн зохицуулалтын арга хэмжээний хугацаа, зардлын түвшин

тодорхойлогдоно. Түүнчлэн 2024 онд төлөх гадаад үнэт цаасны хүүгийн зардал 168.9 сая ам.доллартой тэнцэх хуваарьтай байна.

Олон улсын зах зээлд гаргасан манай улсын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх өгөөжийг доорх графикт харуулав.

График 18. Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж 2022.01.01-2023.04.04



Эх үүсвэр: Блүүмбэрг терминал

Дэлхий даяар инфляц түүхэн дээд хэмжээнд хүрч, АНУ-ын Төвбанкны бодлогын хүү өсөж 4.5 - 4.75 хувьд хүрсэн, БНХАУ-ын “Тэг Ковид”-ын бодлого болон Орос, Украины хурцадмал нөхцөл байдал үүссэн энэ хүнд цаг үед манай улстай ижил зээлжих зэрэглэлтэй буюу “В” зэрэглэлтэй орнуудын хувьд олон улсын хөрөнгийн зах зээлээс эх үүсвэр татах боломж огцом хумигдаж байсан. Үүнтэй зэрэгцэн 2022 оны 09 дүгээр сард Блүүмберг платформд Монгол Улсын тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, валютын нөөцийн огцом бууралт, төлбөрийн тэнцлийн алдагдлын талаар мэдээлэл нийтлэгдсэнээр Монгол Улсын Засгийн газрын бондын өгөөж 5-8 дахин нэмэгдэж 40 хувьд хүрч, 2022 оны 12 сард өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдалтай тулгарч байсан.

Сангийн яамны зүгээс олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож, эдийн засгийн үзүүлэлтүүд 2022 оны гүйцэтгэлээр сайжирч, зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэг” бондоос 435.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 209.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлээд байна.

6.1.6. Засгийн газрын дотоод өр

Засгийн газрын дотоод үнэт цаас

Сангийн яамны зүгээс Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сараас эхлэн Монголбанкаар дамжуулан, 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тус тус нээлттэй хэлбэрээр арилжаалж эхэлсэн.

Засгийн газар 2012-2017 онуудын хооронд 15.9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг арилжаалсан бөгөөд үүний 70 хувь буюу 11.1 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголбанкаар, 10 хувь буюу 1.6 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр, үлдсэн 20 хувь буюу 3.2 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг хаалттай хэлбэрээр арилжаалсан байна. Түүнчлэн 2013 онд арилжаалсан үнэт цаасны дундаж хүү 9.6 хувьтай тэнцэж байсан бол үнэт цаас гаргалтын хэмжээ, Төв банкны бодлогын хүү зэргээс хамаарч 2016 онд 16.9 хувь, 2017 онд 13.3 хувьд хүрч өсөж байжээ. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 1,035.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Барих-шилжүүлэх төрлийн концесс

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2021 онд 673.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3 концессын гэрээний хүрээнд 0.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 463.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

График 2019. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, гэрээний тоо



Түүнчлэн, Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолд "Улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдэл, "Барих-шилжүүлэх" концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн векселиэр баталгаажуулахгүй байх;" гэж, Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолд "Концессын гэрээ байгуулах

замаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр үүсгэхгүй байх” гэж тус тус заасны дагуу 2017 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ болон векселийн гэрээ байгуулагдаагүй байна.

6.2. Засгийн газрын өрийн баталгаа

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг Монгол Улсын Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК зэрэг зээл авсан байгууллагууд эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэж байна.

6.2.1. МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа

“Самурай” үнэт цаасанд гаргасан Засгийн газрын өрийн баталгааг 2023 онд эргэн төлнө - МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иенийн “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасны үндсэн төлбөрийг 2023 оны 12 дугаар сард төлөх хуваарьтай байна.

Түүнчлэн, Засгийн газрын өрийн баталгаатай Хөгжлийн банкны 2023 оны 12 дугаар сард төлөгдөх 30 тэрбум иений Самурай бондыг төлөх валютыг тус банкны олгосон зээлийн эргэн төлөлтийн хуримтлагдсан эх үүсвэрээс бүрдүүлж, Монголбанкинд Японы иений валютаар бүрэн байршуулаад байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банк нь нэгэн цогц санхүүгийн систем болж тооцогддог тул Хөгжлийн банкны дахин санхүүжилтийн эрсдэлээс сэргийлж, эх үүсвэрийг бүрэн нөөцөлж чадсан энэхүү арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсад итгэх итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой болж байгаа юм.

6.2.2. “Эрдэнэс Монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна

Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 8.1 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

6.3. Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.2-т “Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна” гэж заасан. Түүнчлэн, 2021 оныг хүртэл байгуулагдаад буй гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээ 13.5 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа ба зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу энэхүү ашиглаагүй зээлийн хөрөнгийг 3-5 жилийн хугацаанд авч ашиглах үүрэг хүлээсэн. Энэ хэмжээгээр төсвийн хөрөнгийн зардал тэлэх, цаашлаад төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх суурь шалтгаан болох төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэхүү ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд 2021 онд 16 орчим тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн байдаг. Цаашид Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, ашиглагдаагүй зээлийн хэмжээг хязгаарлах, гадаад зээлийн гэрээ хэлэлцээр байгуулахаас өмнөх төслийн бэлтгэл ажлыг Монголын талаас шуурхайлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн бэлэн байдал хангагдсан, бодит секторт чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийснээр Засгийн газрын гадаад зээлийн бодлогын хэрэгжилт сайжирч, төсвийн зардал дахь ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлж буй шимтгэлийн хэмжээ буурах орчин нөхцөл бүрдэнэ.

Зорилт 2. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

Дэлхийн хамгийн том эдийн засаг болох АНУ-ын инфляцын түвшин 2022 оны 3-р сарын байдлаар сүүлийн 40 жилийн хугацаан дахь хамгийн дээд түвшиндээ хүрсний улмаас тус улсын Төв банкнаас бодлогын хүүгийн түвшнийг 2 хувьд хүргэх тухай урт хугацааны зорилтоо олон нийтэд мэдэгдсэн. Улмаар АНУ-ын бодлогын хүү өсөх нь ам.долларын ханш бусад улсын валютын эсрэг чангарах, дэлхийн санхүүгийн зах зээл дээрх суурь хүүг нэмэгдүүлэх зэрэг нөлөө үзүүлснээр Засгийн газрын өрийн багц дахь валютын болон хүүгийн түвшний эрсдэлийг нэмэгдүүлэх, гадаад өрийн дахин санхүүжилтийн зардлыг өсгөх зэрэг сөрөг үр дагавруудтай тул

Засгийн газраас цаашид дээрх эрсдэлүүдээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зорилт 3. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулах.

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа нь хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэйн зэрэгцээ төсвийн алдагдлыг санхүүжүүлэх найдвартай эх үүсвэр болдог тул дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх зорилт нь Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу стратегийн баримт бичгийн зорилго, хамрах хүрээний салшгүй хэсэг болж хуульчлагдсан. Иймд 2017 оны 10 дугаар сараас эхлэн зогсоод буй Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн арилжааг дахин нээж, тогтмолжуулах нэн шаардлагатай байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруйг бий болгосноор хөрөнгийн зах зээлд эрсдэлгүй үнэт цаасны жишиг хүү тогтох өндөр ач холбогдолтой бөгөөд Засгийн газрын газрын үнэт цаасны арилжааг урьдаас зарласан хэмжээ, нөхцөл бүхий хуваарийн дагуу тогтсон хугацаанд зохион байгуулж хэвшсэнээр үнэт цаасны эрэлтийг дэмжиж, өгөөжийн муруйг бий болгох нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Энэ ч үүднээс зарим тохиолдолд Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн дутагдал үүсээгүй байхад Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.3-т заасан зориулалтаар буюу дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх зориулалт бүхий үнэт цаасны арилжаа хэвийн явагдах шаардлагатай болно.

Зорилт 4. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангах, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлах.

“Шинэ сэргэлтийн бодлого” батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү бодлогын баримт бичиг нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг арилгаж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангах зорилтот төсөл хөтөлбөрүүд, хуулийн төслүүд, үйл ажиллагааны хөтөлбөрүүдээс бүрдсэн. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд тулгарч буй нийтлэг асуудлууд нь төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангалтгүй /Техник, эдийн засгийн үндэслэл, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, Зураг, төсөл боловсруулагдаагүй, шинэчлэх шаардлагатай гэх мэт/ байхын зэрэгцээ, төслийг санхүүжүүлэх улсын төсвийн боломж бололцоо хомс байдаг. Иймд төслийн бэлтгэл ажил хангагдсан төсөл, хөтөлбөрийн хувьд улсын төсөвт дарамт учруулалгүйгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжит хувилбар бол хөрөнгө оруулалтын эх үүсвэрт Засгийн газрын баталгаа гаргах явдал юм.

Зорилт 5. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

Өрийн ил тод байдлыг хангуулах, олон нийтэд үнэн бодитой мэдээлэл хүргэх нь иргэн, аж ахуй нэгжид Засгийн газрын үйл ажиллагааг таниулах, төсөвт үүсэж болзошгүй өр төлбөрийн талаар зөв ойлголтыг өгөх, цаашлаад хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, олон улсын санаачилгын хүрээнд дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу өрийн статистик мэдээлэлд Монгол Улсын Засгийн газрын өрийн бүртгэлийг нэгтгүүлэх зэрэг чухал ач холбогдолтой байдаг. Энэ талаар олон улсын байгууллагууд, тэр дундаа Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас Монгол Улсад хуваарилах дунд хугацааны зээлийн хэмжээ, нөхцөлийг тогтооход тавигдсан өрийн ил тод байдлыг хангуулах бодлогын нөхцөлүүдтэй энэхүү зорилт нийцэж байна.


Зорилт 6. Өрийн зохицуулалтын арга хэмжээ.

Дэлхийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын хөрөнгийн зах зээлийн гэнэтийн өөрчлөлт, төлөв байдлаас хамааран Засгийн газрын гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагууд энэхүү стратегийн баримт бичгийн хугацаанд үүснэ. Тухайлбал 2023-2024 онуудад Засгийн газрын гадаад бондын төлөлтийн хувьд өндөр ачаалалтай жилүүд болж байна.

Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

Өрийн тогтвортой байдлын шинжилгээнд аливаа улсын Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг. Монгол Улсын Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх харьцаа 2021 онд 62.6 хувь байгаа ба 2025 он хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд тус харьцаа 50 хувиас их байхаар төсөөлөгдөж байгаа тул “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд орж байна.


График 21. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс /2015-2022/



Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ний өсөлт болон бодит хүүгийн түвшнээс хамаарсан байна. Цаашид ч бодит ДНБ-ний өсөлтийг дэмжиж, төсвийн үндсэн тэнцлийг бууруулах нь өрийн тогтвортой байдлыг хангах суурь үндэс болохоор байна. 2020 оны хувьд цар тахлаас шалтгаалж төсвийн тэнцэл алдагдалтай, ханш суларсан бодит эдийн засгийн өсөлт сөрөг гарсан тул өрийн хэмжээ нэмэгдсэн байна. 2022 онд валютын ханш огцом суларсан ч эдийн засгийн бодит өсөлт, инфляцын түвшин өндөр байгаагаас шалтгаалж ДНБ-ний хэмжээ өссөн нь ДНБ-д эзлэх өрийн хэмжээг буурахад нөлөө үзүүлсэн байна.

Өрийн эмзэг байдлын шинжилгээ

Монгол Улсын өрийн эмзэг байдлыг одоогийн тоон мэдээлэлд үндэслэн үнэлбэл бондын өгөөжийн зөрүү, гадаад санхүүжилтийн хэрэгцээ, Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт, Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын гадаад валютаарх өр зэрэг 5 үзүүлэлтийн 3 нь анхааруулах дээд түвшнээсээ давсан байна.



- Бондын өгөөжийн зөрүү:** МУЗГ-ын олон улсын зах зээлд гаргасан бондын 3 сарын дундаж өгөөж АНУ-ын ижил хугацаатай ЗГ-ын бондтой харьцуулахад 3.32 хувиар өндөр буюу үүнтэй дүйцэхүйц эрсдэлийн нэмэгдэлтэй хэмээн зах зээлд үнэлэгдэж байна. Энэ нь нь дээд анхааруулах түвшин 6 хувиас бага үзүүлэлт юм.
- Гадаад санхүүжилтийн хэрэгцээ:** 2020 оны урсгал тэнцэл, улсын болон хувийн секторын гадаад өрийн үйлчилгээний төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдох ДНБ-д эзлэх уг үзүүлэлт 12 байгаа нь дээд анхааруулах түвшин 15 хувиас бага буюу гадаад санхүүжилтийн хэрэгцээний хувьд дундаж эрсдэлтэй гэсэн үр дүнг үзүүлж байна.
- Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт:** 2020 оны гүйцэтгэлээр нийт өрд эзлэх ЗГ-ын богино хугацаат өрийн үлдэгдэл 0.6 хувиар буурсан байгаа нь бага эрсдэлтэй гэсэн үр дүнг харуулж байна.
- Засгийн газрын гадаад өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 45 хувь бөгөөд манай улсын хувьд 97 хувь байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад санхүүжилтээс хэт их хамааралтайг харуулж байна.
- Засгийн газрын гадаад валютаарх өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 60 хувь бөгөөд манай улсын хувьд 97 хувь байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад валютын ханшийн эрсдэлд эмзэг байгааг илтгэнэ.

6.4. Монгол Улсын Зээлжих зэрэглэл

Улсын зээлжих зэрэглэл (Sovereign Credit Rating) гэдэг нь тухайн улсын хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх гол шалгуур үзүүлэлт бөгөөд гадаад, дотоод хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээлийн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм.

Зээлжих зэрэглэл тогтоогч олон улсын агентлагууд нь улсын зээлжих зэрэглэлийг үнэлэхдээ макро эдийн засаг, улсын төсөв, санхүүгийн нөхцөл байдал, гадаад эрсдэлд мэдрэг байдал болон улс төрийн тогтвортой байдал, засаглалын оновчтой байдал зэргийг харгалзан үнэлдэг.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хамгийн сүүлийн байдлаар Фитч агентлаг 2022.05.18-ны өдөр, Эс энд Пи агентлаг 2022.07.29-ний өдөр, Мүүдис агентлаг 2023.02.14-ний өдөр тус тус дараах байдлаар үнэлээд байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15 Монгол Улсын зээлжих зэрэглэл /2023.04.15 өдрийн байдлаар/

Огноо	Мүүдис (Moody's)		Фитч (Fitch)		Эс энд Пи (S&P)	
	2021.03.21	2023.02.14	2021.05.25	2022.05.18	2021.07.09	2022.07.29
Урт хугацаат	B3	B3	B	B	B	B
Богино хугацаат	-	-	B	B	B	B
Төлөв	Тогтвортой	Тогтвортой	Тогтвортой	Тогтвортой	Тогтвортой	Тогтвортой
Өөрчлөлт	Хэвээр хадгалсан		Хэвээр хадгалсан		Хэвээр хадгалсан	

Монгол Улсад өгсөн зээлжих зэрэглэлийн дундаж нийлбэр дүнгээр В/В/В3 буюу хөрөнгө оруулалтын өндөр эрсдэлтэй ангилалд ороод байна.

Хүснэгт 16 Зээлжих зэрэглэлийн түвшин, эрсдэл

	ЭС ЭНД ПИ	ФИТЧ	МҮҮДИС	ТАЙЛБАР
1	AAA	AAA	Aaa	Хамгийн бага эрсдэлтэй
2	AA+	AA+	Aa1	Маш бага эрсдэлтэй
3	AA	AA	Aa2	
4	AA-	AA-	Aa3	
5	A+	A+	A1	Бага эрсдэлтэй
6	A	A	A2	
7	A-	A-	A3	
8	BBB+	BBB+	Baa1	Дунд зэргийн эрсдэлтэй
9	BBB	BBB	Baa2	
10	BBB-	BBB-	Baa3	
11	BB+	BB+	Ba1	Тодорхой хэмжээний эрсдэлтэй
12	BB	BB	Ba2	
13	BB-	BB-	Ba3	
14	B+	B+	B1	Өндөр эрсдэлтэй
15	В/Тогтвортой	В/Тогтвортой	B2	
16	В-	В-	В3/Тогтвортой	

17	CCC+	CCC+	Сaa1	Маш өндөр эрсдэлтэй
18	CCC	CCC	Сaa2	
19	CCC-	CCC-	Сaa3	
20	CC	CC	Ca	Дефолт болох эрсдэлтэй
21	R	C	C	Дефолт
22	SD	RD		
23	D	D		

Зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудаас Монгол Улсын зээлжих зэрэглэлд “В/В/В3 тогтвортой” гэсэн үнэлгээ өгөхөд дараах хүчин зүйлс нөлөөлөөд байна. Үүнд:

- Дунд хугацаанд Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтвортой хэвээр байхаар хүлээгдэж байгаа;
- Засгийн газрын өрийн удирдлага сайжирч өмнөх үетэй харьцуулахад тогтвортой түвшинд хүрсэн нь нөлөөлсөн байна. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 сард авч хэрэгжүүлсэн гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээ нь Засгийн газрын ирэх жилүүдийн санхүүгийн хэрэгцээг бууруулж, өрийг удирдаж болохуйц хэмжээнд хүргэсэн;
- БНХАУ-ын Ковидын эсрэг арга хэмжээ зөөлөрч, Монголын дэд бүтэц, логистик болон уул уурхайн томоохон төслүүд амжилттай хэрэгжиж байгаа нь гадаад валютын орлогыг дахин сэргээх, ДНБ-ийг ирэх жилүүдэд нэмэгдүүлэхэд томоохон дэмжлэг үзүүлсэн тухай тайландаа дурдсан байна;
- Оюу Толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт урагшилж байна.

Зээлжих зэрэглэл тогтоогч агентлаг тус бүр улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайландаа зээлжих зэрэглэлийг сайжруулахад болон бууруулахад нөлөөлөх хүчин зүйлийг анхааруулга болгон тусгадаг бөгөөд тус хүчин зүйлсийг тогтвортойгоор сайжруулан ажилласнаар манай улсын зээлжих зэрэглэл сайжрах өндөр ач холбогдолтой билээ.

Хүснэгт 17 Монгол Улсын зээлжих зэрэглэлийг цаашид сайжруулахад болон буурахад нөлөөлөх гол хүчин зүйлс


Хувилбар	Тайлбар
Зээлжих зэрэглэлийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлс	<p>Зээлжих зэрэглэлийг сайжруулахад :</p> <ul style="list-style-type: none"> • ГВАН-ийг тогтвортой нэмэгдүүлэх; • Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийг хангаснаар дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өр төлбөрийг тогтворжуулах; • Эдийн засгийн өсөлт, экспортын орлогыг тогтворжуулах, нэмэгдүүлэх; • ГШХО-ыг нэмэгдүүлэх, дэмжих бизнесийн таатай орчныг бүрдүүлэх • Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг бууруулахтай зэрэгцэн төсвийн алдагдлыг бууруулах; • Засгийн газрын гадаад өрийг зохистойгоор удирдах, бууруулах;

	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулж, төсвийн удирдлагыг сайжруулах; • Эдийн засгийн өсөлт уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа бууруулж, эдийн засгийг улам төрөлжүүлэх; • Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх.
Зээлжих зэрэглэлийг хэвээр бууруулахад нөлөөлөх хүчин зүйлс	Зээлжих зэрэглэлийг бууруулах: <ul style="list-style-type: none"> • Гадаад санхүүжилтийн эх үүсвэр татах чадвар буурах, ГВАН нь БНХАУ-ын хилийн боомтын асуудлаас үүдэн буурах үзэгдэл ажиглагдсан зэргээс үүдэн гадаад нөхцөл байдлын эрсдэл нэмэгдэх; • Төсвийн алдагдлыг бууруулж чадахгүй байх, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх харьцааг тогтворжуулж чадахгүй байх; • Улс төрийн тогтворгүй байдал нь ГШХО-ыг бууруулах, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг зогсоох эрсдэлтэй байна • Засгийн газрын санхүүжилт, зээлийн хэрэгцээ шаардлага ихээр нэмэгдэх; • Засгийн газрын өрийн хөрвөх чадварын эрсдэл; • Макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц гадаад санхүүжилтийн дутагдал.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад авах шаардлагатай арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Сангийн яамны зүгээс зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдад Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлын талаарх мэдээг тухай бүр хүргэн, олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ тухай бүр хариуцлагатайгаар хүлээж Засгийн газрын гадаад үнэт цаасны эргэн төлбөрүүдийг цаг хугацаанд нь эргэн төлж ажилласнаар олон улсын санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдалгүй ажиллаж байна.

Ийнхүү ажилласны үр дүнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн түвшин Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, Орос-Украины зэвсэгт мөргөлдөөн, дэлхий даяарх үнийн өсөлт, Төв банкнуудын мөнгөний хатуу бодлого зэрэг санхүүгийн салбарын тодорхойгүй нөхцөл байдлын үед ижил зээлжих зэрэглэлтэй бусад улсуудтай харьцуулахад зээлжих зэрэглэлээ амжилттай тогтвортойгоор хадгалан "B3 (Moody's) / B (S&P) / B (Fitch) Тогтвортой" төлөвтэй байна.

График 22 : Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний өөрчлөлт (2009-2023)



Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон “Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгүүдэд “Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлж, цаашид сайжруулан ажиллана” гэж тус тус туссан. Энэ дагуу Монгол Улсын хөгжлийн бодлогын хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах Сангийн сайдын 2022 оны 160 тоот тушаалаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоолгох ажлын хүрээнд макро эдийн засаг, төсөв, санхүү, өрийн тогтвортой байдлыг хангах бодлогыг баримтлан ажиллах, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудад тогтмол шаардлагатай мэдээлэл хүргүүлэх, холбогдох уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулах, үүрэг бүхий байнгын ажиллагаатай Ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулан ажиллаж байна.

Цаашид Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшлийн санхүүжилтийн зардлыг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татан эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалан ажиллахад гол чухал үзүүлэлт болох Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад Засгийн газрын бүхий л яамд, агентлагууд, Монголбанк зэрэг төрийн байгууллагууд улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллахад бодлогын болон үйл ажиллагааны уялдаа холбоог ханган ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Засгийн газар, төрийн байгууллагууд, Төв банк болон бусад зохицуулагч байгууллагууд хамтран дор дурдсан зээлжих зэрэглэл сайжруулахад нөлөөлөх гол хүчин зүйлсийг сайжруулах чиглэлээр цаашид бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган биелэлтийг ханган ажилласнаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтвортойгоор сайжруулан ажиллах бүрэн боломжтой. Үүнд:

- Гадаад валютын албан нөөцийг тогтвортойгоор нэмэгдүүлэх;

- Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийг хангаснаар дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өр төлбөрийг тогтворжуулах;
- Эдийн засгийн өсөлт, экспортын орлогыг тогтворжуулах, нэмэгдүүлэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих бизнесийн таатай орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг бууруулахтай зэрэгцэн төсвийн алдагдлыг бууруулах;
- Засгийн газрын гадаад өрийг зохистойгоор удирдах, бууруулах;
- Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулж, төсвийн удирдлагыг сайжруулах;
- Эдийн засгийн өсөлт уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа бууруулж, эдийн засгийг улам төрөлжүүлэх;
- Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөрУлаанбаатар
хотМОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2024 он	2025 он	2026 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.5	6.5	5.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	21,163.2	22,472.0	24,089.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.3	30.9	30.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	22,996.1	23,928.8	25,676.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.1	32.9	32.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,520.8	932.7	1,747.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.9	1.3	2.2
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,832.9	-1,456.8	-1,587.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.8	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,850.4	6,145.6	6,406.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.9	8.4	8.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	39,276.0	43,704.0	47,610.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,153.8	2,241.6	2,305.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.3	3.1	2.9

Ажлын хэсгийн нэрс

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхтэй холбоотой Сангийн яамнаас оролцох ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Утас
1	Б.Жавхлан	Сангийн сайд	99113555
2	С.Мөнгөнчимэг	Сангийн дэд сайд	99075752
3	Ж.Ганбат	Төрийн нарийн бичгийн дарга	99104599
4	М.Санжаадорж	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99190219
5	Б.Тэлмүүн	Татварын бодлогын газрын дарга	99087638
6	Б.Сүх-Очир	Санхүүгийн бодлогын газрын дарга	99011664
7	Ч.Чимидсүрэн	Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга	99117344
8	З.Энхболд	Хууль, эрх зүйн газрын дарга	96652191
9	Г.Золбоо	Санхүү, төсвийн судалгааны газрын дарга	99196439
10	Э.Батмөнх	Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга	89992039
11	П.Бат-Эрдэнэ	Төсвийн зарлагын хэлтсийн дарга	99017530
12	Л.Ичинноров	Төсвийн орлогын хэлтсийн дарга	99266680
13	Б.Одонтуяа	Өрийн удирдлагын хэлтсийн дарга	91918565
14	С.Тулга	Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга	98110000
15	Ж.Дэлгэржаргал	Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	99100568
16	Б.Ганзориг	Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга	88005775

САНГИЙН ЯАМ